

ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

Ц.Батсуурь

Хураангуй:

Сургалтын хөтөлбөрийн хөгжлийг хангах гол хөшүүрэг болсон түүний үнэлгээний асуудлыг “Үнэлгээ нь суралцагчийн хөгжлийн бодит байдлын үзүүлэлт, хөгжих хөшүүрэг мөн” гэсэн орчин үеийн хандлагад тулгуурлан товч, цэгцтэй хөндөн тавьж улмаар “хөтөлбөрийн үнэлгээ гэдгийг хэрхэн ойлгох вэ?” гэсэн асуултад хариулахад уншигчдын анхаарлыг хандуулахыг зорьсон болно.

Шинжлэх ухаан технологийн асар түргэн хурдацтай хөгжлийн эрин зуунд боловсролын шаардлага өмнөх үеэс эрс шинэчлэгдэж байгаа нь аливаа сургалтын зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээг нийгмийн хэрэгцээ, хувь хүний сонирхолд нийцүүлэн боловсронгуй болгож байхыг шаардаж байна. Энэ нь зүй тогтол юм. Өөрөөр хэлбэл, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй өөрчлөн хөгжүүлж байхыг шаардаж байна. Ингэхлээр сургалтын Хөтөлбөр нь хөдөлгөөнгүй царцанги баримт бичиг биш, хэрэгцээ төвтэйгөөр хөгжиж байх үйл явц байх ёстой болж байна. Энд би сургалтын хөтөлбөрийн 5 элементийг бүгдийг авч үзэх зорилго тавиагүй, харин хөтөлбөрийн хэр бодтой, суралцагчийн нийгмийн болон хувийн хэрэгцээ, сонирхолд хэр нийцэж байгаагийн шалгуур болсон үнэлгээний шинэчлэлийн талаар асуудал дэвшүүлэхийг эрмэлзсэн болно. Дашрамд дурдахад сургалтын технологийн шинэчлэлийн талаар Лавай сэтгүүлийн 2005 оны 2-рт нийтэлсэн.

Аливаа сургалтыг амжилттай явуулах үндэс нь сургуулийн эрхэм зорилго, нийгмийн хэрэгцээ шаардлага, суралцагчийн авьяас сонирхол гэсэн 3 гол элементийг зөв хослуулах явдал билээ. Эдгээр нь хэрхэн зөв хосолж хэрэгжиж байгааг тодорхойлох гол Хэмжүүр нь ҮНЭЛГЭЭ юм. Өмнө нь бид үнэлгээг ихэвчлэн суралцагчийн мэдлэгийг хэмжих хэмжүүр гэж явцуугаар ойлгож байсан билээ. Тэгвэл эрин цагийн шаардлагын түвшинд: ҮНЭЛГЭЭ НЬ СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН БОДИТ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ХӨГЖИХ ХӨШҮҮРЭГ гэж тодорхойлох нь илүү оновчтой болно.

Үнэлгээний тухай ойлголтыг яагаад шинэчлэх шаардлага гарч байна вэ?

Энэ нь нийгмийн хөгжлийн өөрчлөлттэй уялдан нийгэм, иргэдийн хэрэгцээ өөрчлөгдөх улмаар иргэдийн сонирхолд өөрчлөлт орохоос үүдэж боловсролын зорилго тасрал өөрчлөгдөх ёстой болж байгаа юм. Энэ бүхэн нь сургалтын хөтөлбөрийг үйл явц болгон Хөгжүүлж үнэлгээг тасралтгүй өөрчилж бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлж байхыг зайлшгүйг нотолж байна. Ийм учраас мэдлэг шалгаж үнэлдэг байсан хэлбэрийг өөрчилж суралцагчийн чадварыг үнэлэхэд чиглүүлэх шаардлага буй боллоо. Чадварыг үнэлэх шаардлага буй боллоо. Чадварыг үнэлэх гэдэг нь суралцагчийн мэдээлэлтэй хэрхэн ажиллаж байна гэдгээс мэдлэгийг хэрхэн бүтээж чадаж байна вэ гэдгийг үнэлэх явдал юм. Энэ утгаараа үнэлгээ нь нэг талаас суралцагчийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг хэмжих хэмжүүр, нөгөө талаас өөрийгөө хөгжүүлэх хөшүүрэг болно.

Үнэлгээг өмнөх хөндлөнгөөс хийдэг байсан нь өрөөсгөл талтай. Харин дээр дурдсан шаардлагыг хангах үүднээс эхлээд өөрийн үнэлгээг хийлгэж улмаар хөндлөнгийн үнэлгээг явуулах шаардлагатай. Хөндлөнгийн үнэлгээ нь ч бас олон төрөлтэй Үүнд:

Бүлгийн үнэлгээ, анги хамт олны үнэлгээ, багшийн үнэлгээ, сонирхлын бүлгийн үнэлгээ гэх мэт байж болно. Өөрийн ба хөндлөнгийн үнэлгээ нь явцын ба эцсийн үр дүнгийн үнэлгээ гэсэн

хэлбэрүүдтэй байх бөгөөд явцын үнэлгээ нь суралцагчийг урамшуулах, сайжруулах, хөгжүүлэх чиглэх бол эцсийн үр дүнгийн үнэлгээ нь хөгжлийн бодит байдлыг нотлох, хөгжих боломжийг буй болгоход чиглэгдэнэ. Үнэлгээ нь хүрээний хувьд бүлгээр, ангиар, ганцаарчилсан байдлаар хийгдэнэ. Үнэлгээ нь зөвхөн үнэлээд зогсохгүй сургалтын явцад сайжруулах, санал зөвлөгөө өгөх, давуу ба сул талыг нь тодорхойлох, хариуцлага буй болгох, ач холбогдлыг нь мэдрүүлэх зэрэг хэрэглээтэй байна.

Үнэлгээнд тавигдах нэн чухал шаардлага нь түүний бодот чанар байдаг. Тэгвэл үнэлгээний үнэн бодот байдал нь материаллаг болон сэтгэл зүйн таатай орчинд олон арга хослуулан тасралтгүй явуулж хөгжих боломжийг хэрхэн хангаж байгаагаас шууд шалтгаална. Үнэлгээ хийх орчин нь нэг талаас анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг материаллаг нөхцөл, нөгөө талаас суралцагчийн болон үнэлгээ хийж буй хүн, хамт олны сэтгэл зүйн тааламжтай байдал юм. Олон арга хосолсон гэдэг нь ярилцлага, тест, даалгавар, суралцагчийн оролцооны байдал зэргээс нөхцөл байдалд тохируулан сонгож хэрэглэх явдал юм. Тасралтгүй байна гэдгийг нэг талаас агуулгын хувьд, цаг хугацааны хувьд, нөгөө талаас үнэлэх хэмжүүрийн хувьд ойлгох нь зүйтэй. Харин хөгжих боломжтой гэдэг нь үнэлгээний үр дүнд суралцагч алдаагаа ойлгодог, арга замаа сонгож чаддаг, урамшдаг, улмаар өөрийгөө зөв үнэлэх чадвартай болоход оршино.

Суралцагчийн үнэлгээ нь цаашилбал хөтөлбөрийг үнэлэхэд хүргэнэ. Учир нь суралцагчийн үнэлгээнээс суралцагчийн нийгмийн болон хувь хүний хэрэгцээ, сонирхол хэрхэн хангагдаж байгааг тогтоож болох бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөр зорилго, зорилтын хувьд, агуулгын болон арга зүйн хувьд хэрхэн нийцэж байгааг харуулна.

Сургалтын хөтөлбөрт үнэлгээний талаар маш тодорхой оруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, юуг үнэлэх, яагаад үнэлэх, хэдийд үнэлэх, яаж үнэлэх, хэн үнэлэх, үүний ач холбогдол нь юу болох зэргийг оновчтой, тодорхой тусгах бөгөөд энэ нь суралцагчдад сургалтын эхэнд ил Тод байх ёстой. Ер нь сургалтын хөтөлбөр өөрөө суралцагчдын гарын авлага байх шаардлагатай. Өмнө өгүүлснээр нийгмийн эрэлт хэрэгцээ, суралцагчийн сонирхлын өөрчлөлтийн дагуу сургалтын хөтөлбөр байнга боловсронгуй болж шинэчлэгдэх үйл явц болж байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хөтөлбөр тасралтгүй хөгжиж байх ёстой.

Хөтөлбөрийн хөгжлийг хангах гол хөшүүрэг бол түүний үнэлгээ байдаг. Хөтөлбөрийн ҮНЭЛГЭЭГ Өөрийн ба хөндлөнгийн гэсэн хэлбэрээр хийх нь зохимжтой. Өөрийн үнэлгээг тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш, тэнхим, хамтлаг, сургуулиас хийх ба хөндлөнгийн үнэлгээг магадлан итгэмжлэх байгууллага, сонирхлын бүлгүүд, ажил олгогчийн зүгээс хийнэ. Хөтөлбөрийг үнэлэхэд суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг агуулсан багтаамжийг Тооцсоны үндсэн дээр тодорхой хугацаанд авч, түүний хөгжилд чухал ач холбогдолтойг хөгжилд чухал ач холбогдолтойг анхаарах хэрэгтэй. Хөтөлбөрийг үнэлэх явцад түүний зорилго, зорилт, агуулга, технологийн эрэлт хэрэгцээнд хэрхэн нийцэж байгаа байдал, эдгээрийн хоорондын уялдаа холбоо хэр оновчтой байгаа зэргийг оновчлон тогтоож хөгжүүлэх боломж буй болно. Эцэст нь хөтөлбөрийн үнэлгээ гэдгийг чухам юу гэж ойлгох вэ гэдэгт хариулт өгье.

ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ НЬ ТУХАЙН ХӨТӨЛБӨР НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ, ХУВЬ ХҮНИЙ СОНИРХОЛД ХЭРХЭН НИЙЦЭЖ БУЙН БОДОТ ҮЗҮҮЛЭЛТ, ХӨТӨЛБӨРИЙН ХӨГЖЛИЙН ХӨШҮҮРЭГ ЮМ.


Энд товч өгүүлснийг илүү ойлгомжтой болгох үүднээс схемчлэн үзүүлсэнтэй танилцахыг хүсье.

(2006 / 3)


Боловсролын онол – арга зүйн улирал тутмын сэтгүүл


Үнэлгээний шинэчлэл

Сургалтын хөтөлбөр





1









4











Хөтөлбөрийн үнэлгээ: Хөтөлбөр нийгмийн хэрэгцээ хувь хүний сонирхолд хэрхэн нийцэж буй бодит байдлын үзүүлэлт, хөтөлбөрийн хөгжих хөшүүрэг